

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
АРХИВЫН ТАСАГ

ТАЙЛАН

2015 оны 12 сарын 18

Ховд

Тасгийн 2015 онд хийгдсэн ажлын гүйцэтгэл

Нэг. Зохион байгуулалтын талаар

Тасгийн 2015 оны хийх ажлын төлөвлөгөөг 6 анги 27 асуудлаар төлөвлөж, ажлын гүйцэтгэл 95,7 хувьтай байна.

Төрийн архивын баримтыг цахимжуулалтын хүрээнд Засгийн газрын 2014 оны тогтоолоор гэрээт ажилтны ажиллах хугацааг гурван жилээр сунгасан холбоотойгоор Архивын ерөнхий газрын даргын 2015 оны тушаалаар гурван гэрээт ажилтанг томилж, Архивын ерөнхий газрын дэд дарга, үндэсний хөтөлбөрийн ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, гэрээт ажилтнууд гурвалсан гэрээг байгуулж, гэрээт ажилтнууд архивын баримтыг цахимжуулах графикт төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан, гүйцэтгэлийг 7 хоногоор, сар, улирлаар тооцож ажиллалаа.

Үндэсний хөтөлбөрийн ажлын хэсэгт сарын бүрийн 25-нд гэрээт ажилтнуудын норм нормативын биелэлтийг тогтмол гаргаж хүргүүлэн мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажилласан.

Архивын Ерөнхий газрын Сургалт, судалгааны газрын сургалтын төвд аймгийн Булган Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн эрхлэгч Г.Мөнхцэцэг, Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Ганчимэг, Үенч сумын Эрүүл мэндийн төвийн статистикч бага эмч М.Машбат, аймгийн Халамж, үйлчилгээний хэлтсийн архив, албан хэрэг хөтлөлө хариуцсан ажилтан Д.Даваажаргал нар анхан болон мэргэшүүлэх сургалтанд захиалгын дагуу хамрагдлаа.

2015 оны 04 дүгээр сарын 29-нээс 05 дугаар сарын 02-ны хүртэл Улаанбаатар хотын “Гурусофт” ХХК-тай хамран 17 сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын Тамгын

газар, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 17 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн 3, Ховд нисэх буудал 1, Зургаадугаар тойрогийн Тахарын алба 1, Ховд их сургууль 1, Хөгжил полтехник коллеж 1, Баруун бүсийн оношилгоо эмчилгээний төв 1 нийтдээ 44 байгууллагад архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн “AMS” программ суулгаж архив, албан хэрэг хөтлөлтийн цахим хэлбэрт шилжүүлэх ажил аймгийн хэмжээнд хийгдэх бүрэн боломжтой боллоо.



“Улсын үзлэг явуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 5 сарын 18-ны өдрийн 195 дугаар тогтоол, “Улсын үзлэг явуулах төв комиссын бүрэлдэхүүн, удирдамжийг батлах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 5 сарын 18-ны өдрийн 124 дүгээр захирамж хүрээнд аймгийн Засаг даргын 2015 оны А/307 дугаар захирамжаар улсын үзлэгийг

аймагт зохион байгуулах аймгийн салбар комиссын бүрэлдэхүүнийг томилж, комиссын хуралдаанаар үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө, үзлэгт хамрагдах сум, байгууллагын жагсаалт, сум, байгууллагуудад зохион байгуулах сургалт, семинар хөтөлбөр баталж, 2015 оны 07 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд аймгийн сум, байгууллагын дарга, сүлжээний ажилтан, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан 126 хүнд төрийн байгуулалтын ажлын зохион байгуулалтын ажлын чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн сум, байгууллага хариуцсан мэргэжилтэн Б.Ганболд, хүний нөөц хариуцсан, төрийн албаны зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Оюунчимэг, Мэдээллийн технологи чиглэлээр төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн сүлжээ хариуцсан мэргэжилтэн Д.Дөмөгтүшиг, Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр Хууль зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга С.Батдорж, Төрийн нууц, байгууллагын нууцын талаар Ховд



аймаг дахь Тагнуулын газрын ажилтан хошууч М.Энхтайван, мэдээллийн аюулгүй

байдал, кибер халдлага, компьютерийн нууц үгийн чиглэлээр дэслэгч М.Ганбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр сургалт, семинар зохион байгууллаа.

Үзлэгийг аймагт зохион байгуулах аймгийн Салбар комиссын 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан удирдамж, хуваарийн дагуу аймгийн урьдчилсан үзлэгийг Ажлын 5 хэсэгт зохион байгуулан 138 байгууллага хамрагдсан.

Урьдчилсан үзлэгийг 4 чиглэлээр дүгнэхэд нийтдээ авбал зохих 425000 оноос 271580 оноо авсан буюу дундаж оноо 63 хувьтай шалгагдлаа.

Аймгийн хэмжээнд явуулсан урьдчилсан үзлэгийн дүнг хэлэлцээд салбар комиссоос шийдвэр гаргаж, аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр албан даалгавар гаргаж 2015 оны 08 дугаар сарын 23-ны дотор ирүүлэх үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцож ажилласан.

#### Хоёр. Нөхөн бүрдүүлэлт, тоо бүртгэлийн ажлын талаар

Аймгийн Баримт бичгийн нягтлан шалгах комиссын хурлыг 2015 оны 01 дүгээр сард 01 дүгээр хурлаар комиссын 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, 2015 оны хийх ажлын төлөвлөгөөний төсөл, 2015 онд төрийн архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтэд гарч байгаа бэрхшээлийг тус тус хэлэлцлээ.

2015 оны 06 сард комиссын 02 дугаар хурлаар татан буугдсан аймгийн Тээвэр, авто замын газрын байнга, түр хадгалах, Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгуулалт ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах асуудлаар хэлэлцэж, сум, байгууллагын түвшинд амжилт бэлтгэн оролцох, татан буугдсан байгууллагын баримтыг нөхөн бүрдүүлэхээр тус тус шийдвэрлэсэн.

2015 оны 08 дугаар сард комиссын 03 дугаар хуралдаанаар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2001- 2009 оны байнга хадгалах баримт хүлээн авах асуудлыг хэлэлцэж, комиссын шийдвэрээр хүлээн авч данс бүртгэл үйлдлээ.

2015 оны 12 дугаар сард комиссын 04 дүгээр хуралдаанаар Монгол, Шуудан банк, Хадгаламж банкны байнга, түр, түр 70 жилийн баримтаар нөхөн бүрдүүлэлт хийхээр хуралдан, комиссын шийдвэрээр хүлээн авч данс бүртгэл үйлдлээ.

Засгийн газрын 2015 оны тогтоолоор татан буугдсан аймгийн Тээвэр авто замын байнга, түр хадгалах, түр 70 жил хадгалах 2000-2014 оны 106 ширхэг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1995-2009 оны байнга хадгалах

381 ширхэг, Монгол шуудангийн 1992-2010 оны байнга 20 , түр 3293 , түр 70 5 ширхэг, Хадгаламж банкны 1997-2013 оны байнга 34 , түр 3819 , түр 70 жил 8 ширхэг, Геологийн “Алтай” нэгдлийн 1981-2000 оны байнга хадгалах 22 ширхэг баримтаар төрийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлж хийж, данс бүртгэл үйлдлээ.

Улсын болон орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр шинээр баригдсан, их засвар хийгдсэн 2015 оны 39 байгууламжийн баримт бичгүүдийг нягтлан шалгаж, эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийж, данс бүртгэл баяжилт хийллээ.

Гурав. Тоо бүртгэл, хамгаалалт, хадгалалт, эрдэм, шинжилгээ, мэдээлэл лавлагааны сангийн ажлын талаар

Төрийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 9 хөмрөгийн 1951-2001 оны захирамж, тушаал 329 ширхэг хадгаламжийн нэгжийг данс, бүртгэлтэй тулган, хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийллээ.

Нягтлан шалгалтын явцад 4 хөмрөгийн дансны бүртгэлийг шинэчилсэн. Үүнд:

86 дугаар хөмрөг буюу Барилга захиалагчийн товчоо 2014-2015 он

105 дугаар хөмрөг буюу Эрдэнэбүрэн сумын Тэжээлийн аж ахуй 1987-1992 он

115 дугаар хөмрөг буюу Ховд сумын Худалдаа бэлтгэлийн анги 1974-1992 он

106 дугаар хөмрөг буюу Геологийн “ Алтай” нэгдэл 1981-2000 он тус тус хөмрөгийн данс, бүртгэлийг шинэчиллээ.

Тасгийн жилийн ажлын төлөвлөгөө болон цахимжуулалтын ажлын хүрээнд 329 хадгаламжийн нэгж буюу 16463 хуудсыг мастер, ашиглалтын хувь тус тус үүсгэн төрийн архивын программд данс, бүртгэлийг шивж, цахим холболт хийгдээд байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн цогц программ суулгасаны дагуу сум, байгууллагуудад архивт хадгалагдаж буй байнга хадгалах 1978-2014 оны 754 ширхэг хадгаламжийн нэгж буюу 109094 хуудсыг ашиглалт, мастер хувь үүсгэсэн данс бүртгэлийн хамт архивын программ шивээд байна.


Энэ жил нийтдээ аймаг нь төрийн тасаг болон сум, байгууллагуудтай нийлээд 1951-2014 оны 1083 ширхэг хадгаламжийн нэгж буюу 125557 хуудсыг мастер, ашиглалтын хувь болгон үүсгэж, данс, бүртгэлийн хамт архивын программд оруулаад байна.

Аймгийн Төрийн архивын тасаг нь нийтдээ эхний ээлжинд 101 хөмрөгийг захирамж тушаалыг цахимжуулах төвлөгөөтэй бөгөөд одоогийн байдлаар 62 хөмргийн 5317 хадгаламжийн нэгж/ захирамж, тушаал/-ийг мастер болон ашиглалтын хувь үүсгэсэн бөгөөд нийтдээ баримтын 61 хувийг төрийн архивын архивын программд данс бүртгэлийн хамт шивж оруулаад байна.

Төрийн архивын Сан хөмрөгийн өрөөнүүдэд 2015 оны 5, 11 дүгээр сард хортон шавьж устгалыг 2 удаа хийж, өрөөний чийгшилт, дулааны хэмжилтийг өдөр тутам тэмдэглэл хөтөлж, өдөр хоног бүр хуурай цэвэрлэгээ, 14 хоногт нойтон цэвэрлэгээг тогтмол хийж байна.

#### Дөрөв.Баримтын ашиглалт, хэвлэн нийтлэлийн талаар

Тасаг нь 2015 онд 1585 хүнд архивын лавлагаа, магадлагаа олгоод байна.



Үүнд:

556 хүнд тогтоол, захирамж, тушаалын, 579 хүнд цалингийн тодорхойлолтын, 25 хүнд эхийн одон, 38 хүнд хүн амын тооллогын лавлагааны, 387 хүнд холбогдох баримт олдоогүй гэсэн лавлагаа, магадлагаа тус тус олголоо.

Цагаатгах ажлын удирдан зохион байгуулах комиссын 2015 оны 01 дүгээр албан даалгаварын хүрээнд аймгийн Цагаатгах ажлыг удирдах зохион байгуулах аймгийн комиссоос өгсөн чиглэлийн дагуу 01 дүгээр хөмрөгийн буюу аймгийн Засаг даргын Тамгын газрын 1937-1990 оны захиргааны хурлын тэмдэглэл, Намын хороо, захиргааны хамтарсан хурлын тэмдэглэл 83 хадгаламжийн нэгж, 125 дугаар хөмрөг буюу Аймгийн МАХН-ын хорооны 1937-1990 оны Намын хорооны товчооны хурлын тогтоол, нарийн бичгийн дарга нарын зөвлөлийн хурлын тогтоол, тэмдэглэл 164 ширхэг хадгаламжийн нэгж, 82 дугаар хөмрөг буюу аймгийн Шүүхийн 1936-1963 оны Эрүүгийн хэргийн бүртгэл 8

ширхэг хадгаламжийн нэгж, 1964-1990 оны эрүүгийн хэргийн таслан шийтгэх тогтоол 26 ширхэг хадгаламжийн нэгж, 01 дүгээр хөмрөгийн буюу аймгийн Засаг даргын Тамгын газрын 1927-1957 оны 4 ширхэг хадгаламжийн нэгж буюу нийтдээ 4 хөмрөгийн 277 ширхэг хадгаламжийн нэгжийг уншлагын танхимаар ашиглуулсан.



01 хөмрөгийн 1926-1959 оны 4 хадгаламжийн нэгжийг баримтыг Ховд хотын 330 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бүтээлд хэвлүүлсэн

2014 оны аймгийн давсан орлого болох архивын орлогоос 12 сая төгрөгийн өртөгтэй албаны конторын шалыг паркетин шал болгож, модон хаалга төмөр хаалгатай болгож, хананд хөшгөн будаг хийж, архивын

гэрээт ажилтнуудын өрөөний шалыг паркетин шалтай болгож, хөшгөн будаг хийж, халаалтын шугмыг шинэчилсэн, мөн 2 сангийн өрөөний халаалтын шугмыг шинэчилээд байна.



Тав.Хяналт шалгалтын ажлын талаар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 2015 оны 03 дугаар сарын 18-наас 2015 оны 05 дугаар сарын 23-ны хүртэл Дуут, Мөст, Мөнххайрхан Буянт төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтан болон багийн Засаг дарга,

Иргэдийн Нийтийн Хурлын дарга, төрийн албан хаагчид, архив, албан хөтлөлтийн хариуцсан ажилтнуудад тус тус бүр 2 өдрийн сургалт семинар хийж, архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, стандартын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар газар дээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний тасагтай хамтран 2014 онд аймгийн хэмжээнд сүүлийн байрт шалгарсан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандартчлал хэмжилзүйн хэлтэс, Ус

цаг, уур орчны шинжилгээний алба байгууллагуудад дахин хяналт шалгалт хийж, үүрэг даалгавар өгсөн.

Үзлэгийг аймагт зохион байгуулах аймгийн Салбар комиссын 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан удирдамж, хуваарийн дагуу аймгийн урьдчилсан үзлэгийг Ажлын 5 хэсэгт зохион байгуулан 138 байгууллага хамрагдсан.

Урьдчилсан үзлэгийг 4 чиглэлээр дүгнэхэд нийтдээ авбал зохих 425000 оноос 271580 оноо авсан буюу дундаж оноо 63 хувьтай шалгагдлаа.

Аймгийн хэмжээнд явуулсан урьдчилсан үзлэгийн дүнг хэлэлцээд салбар комиссоос шийдвэр гаргаж, аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр албан даалгавар гаргаж 2015 оны 08 дугаар сарын 23-ны дотор ирүүлэх үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцож ажилласан.

Аймгийн Засаг даргын 2015 оны А/34 захирамжаар батлагдсан аймгийн хэмжээнд дагаж мөрдөх ” Хугацаатай бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавих журам ”-ыг боловсруулан баталж, сум, байгууллагууд сарын бүрийн 25-ны дотор тайлагнах ажлын хүрээнд улсын байцаагчийн 2 дүгнэлт гарган сум, байгууллагууд хүргүүлэн биелэлтийг тооцож, хугацаатай бичгийн шийдвэрлэлтэнд бүрэн хяналт тавьж ажиллаа.

#### Зургаа. Бусад ажил

Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Тамгын газар, хэлтсийн төлөвлөгөөнд архивын тасагтай холбоотой заалтуудын биелэлтийг тооцож ажиллалаа.

Энэ жил аймгийн хэмжээнд зохион байгуулсан олон нийтийн ажил, аймгийн Засаг даргын Тамгын газар, хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаанд тасгийн ажилтнуудын идэвхтэй оролцон, өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд биелүүлэн ажилласан.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗЫН ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
АРХИВЫН ТАСАГ